



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/237

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын
баримт бичгийг шинэчлэн батлах тухай


Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Үндэсний Аудитын Газрын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн САГ-2017/324/СТА-ТШЗ аудитийн зөвлөмж, “ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.14.7 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бүтээгдэхүүний өртөг тооцох”, “Эд хөрөнгийн тооллого явуулах”, “Мөнгөн кассын ажиллагааны”, “Үндсэн хөрөнгө олж бэлтгэх”, “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох”, “Нягтлан бодох бүртгэлийн залруулга хийх” журмуудыг багтаан, шинэчлэн боловсруулсан “ШУТИС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хавсралтаар баталж, 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал /Л.Баяр-Эрдэнэ/, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга /Д.Барсболд/ нарт даалгасугай.

3. Энэ тушаалыг гарсантай холбогдуулан Ректорын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-180 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ